

ХИЛ ХАМГААЛАЛТАД ТОДОРХОЙ АХИЦ ГАРНА.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй
байдлын зөвлөлийн ажлтай, хурандаа
П.Баттогтох манай сурвалжлагчийн асуултанд
ийнхүү хариулж байна.

Сурв: Оны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журмыг баталлаа. Энэ тухай дэлгэрэнгүй ярина уу?

П.Б: Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам"-ыг шинэчлэн баталлаа. Энэ нь хилийн тухай Монгол Улсын хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан иргэд, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг улсын хил хамгаалалтад оролцуулах асуудлыг зохицуулах эрх зүйн барилт бичиг юм.

Шинэ журам батлагдсантай холбогдон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1996 оны 19 дүгээр зарлигаар батлагдсан анхны журам хүчингүй болж байгаа бөгөөд энэ журмыг хэрэгжүүлэх хугацаанд улсын хил хамгаалалтад хүч хэрэгсэл хүрэлцэхгүй явдал багасч, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэлт дээшилж, орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас хилийн тухай хуулиар хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэхэд нь үлэмж түлхэц болсон юм. Энэ хугацаанд илрүүлсэн зөрчлийн 8 хувийг туслах хүчний гишүүдийн оролцоо тусламцаатайгаар, туслах хүчний гишүүд бие даан хилийн 71 зөрчлийг тус тус илрүүлсэн.

Хилийн цагийн байдал эрс идэвхижиж байна. 1990 оноос хойш гарсан бүх зөрчлийг 1980-1990 онд гарсан зөрчилтэй харьцуулбал 3 дахин өсчээ. Улсын хилээр хууль бусаар их хэмжээний спирт, ноолуур давуулах, автомашин эд зүйлс хил нэвтрүүлэн гуравдагч орны иргэдийг хил зөрчүүлэн гадаадад гаргах, хилийн малын хулгай, дээрэм тонуулын хэлбэрт шилжих зэргээр зорилго чиглэл нь зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байна.

Зарим тохиолдолд зэвсэг хэрэглэх асуудал гарах болмоо. Улсын хэмжээгээр хун амын амьжиргааны түвшингийн ялгаа ихэсч хөдөө орон нутгаас хот суурин газар шилжих хөдөлгөөн нэмэгдлээ.

орон нутгаас хойт суурин газар шилжих хөдөлгөөн нэмэгдлээ.

Өнөөдрийн байдлаар улсын хил хамгаалалтад хилийн 14 аймгийн 67 сум, 213 багийн нутаг дэвсгэрт 1200 орчим туслах хүчний гишүүд оролцдог.

Хилийн цагийн байдалд нөлөөлж буй гадаад дотоод хүчин зүйлс, улс орны хэмжээнд буй болсон нөхцөл байдал, нийгмийн амьдралын бүх салбарт хийгдэж байгаа эрх зүйн орчныг боловсронгуй болгох, явдалтай үзэлдүүлэн энэхүү журмыг шинээр боловсруулах бодит шаардлага гарч ирсэн юм. Энэхүү журамд туслах хүчний гишүүдэд хөнгөлөлт, урамшуулалт олгох, тэдэнд үүргээ гүйцэтгэх эрх зүйн баталгаа бий болгох, туслах хүчний удирдлага гүйцэтгэх үүрэг хариуцлагыг боловсронгуй болгох, орон нутаг дахь төрийн захиргаа болон нутгийн захиргааны байгууллагуудыг хил хамгаалалтад жигд татан оролцуулах зэрэг олон асуудал шинээр орсон болно.

Уг журмыг шинээр боловсруулахаар хилийн бүх аймаг, төрийн захиргааны төв байгууллага өөрөөр хэлбэл бүх яамдын саналуудыг тусгасныг тэмдэглэж хэлмээр байна.

Сурв: Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөмүүдийн үүргийг тодруулна уу?

П.Б: Хилийн бүх аймаг сумын засаг даргын дэргэд хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөл ажиллана. Шаардлагатай тохиолдолд сумын засаг даргын шийдвэрээр багийн зөвлөлийг ажиллуулж байна. Зөвлөл нь хилийн тухай хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хэрхэн сахин биелүүлж байгааг хянаж шалгах, туслах хүчний хил хамгаалалтад оролцуулах ажлыг улсын хил хамгаалах байгууллагатай хамтран зохион байгуулах, хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч, ажил үйлдвэрлэл эрхэлж байгаа туслах хүчний гишүүдэд хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулж удирдах, туслах хүчний цугларалт нэгдсэн зөвлөмөөнийг зохион явуулах хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг удаа дараа илрүүлсэн гишүүдийг шагнаж урамшуулах зэрэг бусад олон үүрэгтэй байгууллага юм.

Сурв: Зөвлөлийн нарийн бичгийн даргыг орон тооны ажилтан

болгохоор журамд тусгасны учрыг тайлбарлана уу?

П.Б: Туслах хүчний үйл ажиллагааг байнгын удирдлагаар хангах зорилгоор хил хамгаалалтад туслах зөвлөлийн нарийн бичгийн даргыг "орон тооны ажилтан" болгохоор Увс, Баян-Өлгий, Дорноговь, Өмнөговь зэрэг аймгуудын Засаг даргын тамгын газраас санал ирсэн. Энэ саналыг хилийн бусад бүх аймаг дэмжсэн болно. Нөгөө талаар төсвийн өнөөгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай уялдан журамд аймаг сумын засаг дарга нь шаардлагатай гэж үзвэл аймаг сумын зөвлөлийн нарийн бичгийн даргыг тамгын газрын бүтцэд багтаан орон тооны ажилтнаар томилж болно гэж тусгасан. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн өдөр тутмын ажлыг хариуцан зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий төрийн захиргааны ажилтан юм.

Сурв: Хил хамгаалалтад оролцож буй иргэдэд ямар эрх хөнгөлөлт үзүүлэхээр заасан бэ?

П.Б: Хилийн бүс зурваст ажил үйлдвэрлэл эрхэлж байгаа буюу оршин суудаг иргэд хил хамгаалалтад туслах хүчинд үүрэг гүйцэтгэнэ гэдэг нь хүнд хүчир бөгөөд хариуцлагатай ажил гэдгийг цохон тэмдэглэе. Энэ нь улс орны аюулгүй байдал, хилийн халдамгүй дархан байдлыг сахин хамгаалах үйлсэд оруулж буй иргэдийн ариун үүрэг юм. Ийн учраас төрөөс зориуд анхаарч хил хамгаалалтад оролцож буй иргэдэд албан үүргээ гүйцэтгэх эрх зүйн орчныг баталгаажуулах зорилгоор зарим эрх эдлэх хөнгөлөлт, урамшуулал олгохоор шинээр тусгасан.

Тэдгээрээс заримыг нь дурдвал нутгийн захиргаа, цагдаа, хил хамгаалах байгууллагаас мөнгөн урамшуулал авах, хуулинд заасан бүх хөнгөлөлт эдлэх зэрэг эрхтэй бөгөөд туслах хүчний гишүүн нь хил хамгаалах албан үүргээ гүйцэтгэхдээ хувийн машин мотоциклоо ашигласан бол зарцуулсан шатахууныг зохих журмаар авах, машин техникээ засварлахад нь хил хамгаалах байгууллагаас мэргэжлийн тусламцаа үзүүлэх, үнэ төлбөргүйгээр энгэрийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, урлагаар үйлчлэх, тэдний хүссэн тогтмол хэвлэлийг захиалж өгөх, улсын хил хамгаалах албан үүрэг гүйцэтгэх үедээ тусгай

зориулалтын хувцас, холбооны хэрэгсэл шаардлагатай цед зэвсгээр хангагдах, зөвлөлийн даргын шийдвэрээр улсын хил хамгаалах ажилд 5-аас доошгүй жил тасралтгүй идэвх зүйтгэлтэй ажилласан гишүүнд хил хамгаалах байгууллагын ахлагчийн 1-3 сарын цалинтай дүйцэх цалинг жилд 1 удаа олгох "Хилийн төлөө" тэмдэг болон бусад шагнал урамшуулал олгох, мөн албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан туслах хүчний гишүүний гэр бүлд хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1, 2, 7-д заасны дагуу ахлагчийн цалингийн дунджаар тооцон 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тэтгэмж олгох зэрэг юм.

Хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл төсвөөс туслах хүчний гишүүн эмчилгээ хийлгэхээр сумаас аймагт, аймгаас УБ хотод зорчих нэг талын зардлыг гаргах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлийн дагуу хилийн дэглэмийн зөрчил, хил зөрчигчдийг илрүүлэн саатүүлсан, эд барааг хууль бусаар хил нэвтрүүлсэн, бэлтгэж завдаж байгаа тухай үнэтэй мэдээлэл өгсөн туслах хүчний гишүүнд нутгийн захиргаа, хил хамгаалах цагдаагийн байгууллага, сум аймгийн зөвлөлийн дарга урамшуулалд олгох, төрийн дээд шагнал Засгийн газрын шагналд тодорхойлох зэрэг эрхтэй.

Үүнтэй холбогдуулан хил хамгаалах, цагдаагийн байгууллагууд хилийн зөрчилд бэлтгэж байгаа болон хил зөрчсөн талаарх мэдээлэлд урамшуулал олгох журам, гэмт хэргэ үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээлэл худалдан авах журмуудыг тус тус мөрдөн ажиллаж байна. Тэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгжийг нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагаас шагнаж урамшуулдаг сайхан уламжлал бий. Үүнтэй адилаар хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, хууль зүйн дагуу шийдвэрлэх ажилд үр дүн гарган амжилттай ажилласан баг, сум, аймгийн зөвлөмүүдийг шалгаруулж урамшуулах талаар Зөвлөмүүд, хил хамгаалах байгууллага санаачилга гарган ажиллах нь зүйтэй.

Сурв: Уг журам гарснаар хил хамгаалах үйлсэд ямар ахиц гарна гэж бодож байна. Вэ?

П.Б.Тодорхой ахиц гарна гэж бодож байна. Өмнөх журмыг хэрэгжүүлэх хугацаанд үр дүнд хүрсэн зөвхөн нэг л жишээг дурдсан. Ер нь хилийн 14 аймаг 67 сумын хэмжээгээр Зөвлөмүүдийн ажил тогтмолжиж, Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол болсон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үйлсэд их хувь нэмэр оруулсан, хамтран ажиллах ажлын арга барил хэлбэр ч баяжсан. Увс, Ховд, Дорноговь, Өмнөговь зэрэг аймгуудын зөвлөмүүд онцгой үр дүнтэй ажилласныг тэмдэглэж хэлье. Улсын хил хамгаалах ажил бол зөвхөн хил хамгаалах байгууллагын үүрэг бус нийт арга иргэд, аж ахуйн нэгж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн төв байгууллага үүрэг юм. Харин ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалж дээрх бүх байгууллагууд хил хамгаалалтад оор оврийн чиг үүрэгтэй байх нь мэдээж.

Саяхан Монгол Улсын төсвийн тухай УИХ-аар хэлэлцэхэд хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардалд 33 сая төгрөг тусгалаа. ХЦ-ийн төсөвт ч уг журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулж зохих хэмжээний зардал нэмж төсөвт нь тусгах нь гарцаагүй.



Манай сурвалжлагч.